



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/42

Хажуу шинэ-Ус

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгийн 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Дэнжийн тоглоомын талбайн хашааг засаж янзлах, хуучин тоглоомуудыг сэргээж засах” ажилд 11,600,000.00 (Арван нэгэн сая зургаан зуун мянга) төгрөг, “Хүүхдийн цэцэрлэгийн гаднах хашааг үргэлжлүүлж барих, шинээр тоглоом хийх” ажилд 19,000,000.00 (Арван есөн сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн М.Ууганболд ахлагчтай “Очир хийц” иргэний бүлэгтэй дээрх хоёр ажилд тус бүрд нь шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2.Дээрх хоёр ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Очир хийц” иргэний бүлгийн ахлагч (М.Ууганболд)-д даалгасугай.

3.М.Ууганболдтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.АРИУНАА